

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2022/120/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Уранбилэг Утас: 70523020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.22 № 1-6/79

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.ХОСБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

0100200026

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	33.2	47.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	483.1	469.8
	Нийт хөрөнгийн дүн	516.3	517.0
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	516.3	517.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	516.3	517.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,216.5	1,085.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	959.6	1,065.3
	Үйл ажиллагааны үр дүн	256.9	19.9
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(10.0)	(19.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	269.4	516.3
	Тайлант оны үр дүн	246.9	0.5
	Эцсийн үлдэгдэл	516.3	517.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	916.7	1,013.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	916.7	1,013.4
	Үйл ажиллагааны ЦМГ		
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		20.0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	888.4	981.7
	Урсгал зардал	888.4	981.7
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	911.6	992.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн татварын хэлтэс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газраас тодорхойлсон тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан санхүү, эдийн засаг, татварын бодлогын хэрэгжилтийг хангах, улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх,

зөвлөгөө, сургалт сурталчилгаа, үйлчилгээгээр татварын харилцаанд оролцогчдыг хангах

- Татвар төлөгчийн ангилалд тохирсон бүртгэл, татвар ногдуулалт, төлөлт, татвар хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Орчин үеийн мэдээллийн технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж эрсдэлийн удирдлагын тогтолцоонд суурилсан татварын хяналтыг хэрэгжүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Татварын ерөнхий газраас тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 19.5 сая төгрөгийг олгосон байна. Санхүүжилтээр нийт 19.3 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авахаар Болор аграмба ХХК-д шилжүүлсэн байна. Гэвч худалдан авах хөрөнгийн техникийн тодорхойлолт байхгүй буюу шинж чанарын үзүүлэлт, тухайлсан нөхцөл шаардлага, тоо хэмжээ зэрэг нь тодорхойгүй, хүлээн авагч байгууллагын талаарх мэдээлэл байхгүй, гүйцэтгэгч байгууллагыг хэрхэн үнэлсэн нь тодорхойгүй байна. Мөн худалдан авсан гэх 19.3 сая төгрөгийн тавилга, эд хогшил нь тус байгууллагад биетээр хүлээн аваагүй байтал үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, ТЕГ-т балансаас баланст шилжүүлсэн байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа “EMERALD” программыг ашигладаг ба аудитын явцад хөрвүүлсэн журнал санхүүгийн тайлангаас зөрүүтэй, нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан гарахгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 58.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 42.1 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг арилгах тухай 2 зөвлөмж, 16.2 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов.

4.1 Залруулсан алдаа

1. Тайлант хугацаанд цалингийн зардлаас 21.8 сая төгрөгийг ахмадын санд шилжүүлсэн байна. Гэтэл санхүүгийн тайланд тусгаагүй, тусдаа тайлан бэлтгээгүй байна.
2. Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 20.0 сая төгрөгөөр хөрөнгө худалдан авсан байтал мөнгөн гүйлгээний тайланд тусгагдаагүй байна.

3. Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны байгууллагаас нийт 19.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байхад бүртгэлд 19.3 сая төгрөгөөр бүртгэж тайлагнаж, буцаан төвлөрүүлсэн дүнгээр дахин орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Албан шаардлага

1. Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны байгууллагаас нийт 19.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байхад бүртгэлд 19.3 сая төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авсан байна. Худалдан авсан хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байгаа ба ТӨБЗГ-ын 2021 оны 11 сарын 15-ны өдрийн Н-1/1877 дугаар албан бичгээр ТЕГ-т балансаас баланст шилжүүлсэн байна. Худалдан авалтын үеийн баримтыг үзэхэд 19.3 сая төгрөгийн Болор аграмба ХХК-д шилжүүлсэн байгаа ба худалдан авах гэрээ байхгүй, хөрөнгийн техникийн тодорхойлолт байхгүй, ямар тавилга эд хогшил худалдан авах тоо хэмжээ тодорхойгүй, хөрөнгийн дансанд ямар баримтыг үндэслэн бүртгэсэн нь тодорхойгүй, худалдан авсан хөрөнгийг биетээр хүлээн аваагүй байна. Мөн Болор Аграмба ХХК-д яагаад шилжүүлсэн нь тодорхойгүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг зөрчиж байна. Мөн энэ нь засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх," гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Мөн хөрөнгийг биетээр хүлээн аваагүй байтал үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, зарлагдсан байна.
2. Байгууллагын даргын 2021 оны А/36 дугаар тушаалаар тус хэлтсийн татварын улсын /ахлах/ байцаагч нарын нэгдсэн сургалт, семинарыг 2021 оны 12 сарын 16-18-ны хооронд зохион байгуулсан байна. Тус сургалтаар 2.3 сая төгрөгийг хоол, цайны зардалд, 3.5 сая төгрөгийг томилолтын зардалд, нийт 5.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5-д "Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тайлант хугацааны эцэст хэмнэгдэх боломжтой байсан үлдэгдлийг нөөц үүсгэн талон авсан. Энэ нь дээрх тогтоолын 1.1-д "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчиж байна.
3. Тайлант оны ажил гүйлгээг шалгахад нийт 4.5 сая төгрөгийн 16 гүйлгээ нь эдийн засгийн ангилал зөрчсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын

2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн байна.

3.3 Төлбөрийн акт

1. Байгууллагын даргын 2021 оны А/36 дугаар тушаалаар тус хэлтсийн татварын улсын /ахлах/ байцаагч нарын нэгдсэн сургалт, семинарт сумдын 21 байцаагчид томилолтын зардал олгоходоо хүн бүрд унааны зардалд 10.0-20.0 мянган, нийт 0.4 сая төгрөг олгосон байгаа ба унааны зардлын баримт байхгүй байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.10-т "Унааны зардлын баримт (онгоц, галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн тасалбар, автомашин хөлсөлсөн бол ажил гүйцэтгэх гэрээ эсхүл шатахуун худалдан авсан тасалбар)-ыг төрийн албан хаагч албан томилолтын тайландаа хавсаргах ба хоолны болон байрны зардлын баримтыг албан томилолтоор ажилласан төрийн албан хаагчаас шаардахгүй байж болно" гэж заасныг зөрчиж байна.

4.4 Зөвлөмж

Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн журналыг шалгахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 54 нэр төрлийн 54.5 сая төгрөгийн өртөгтэй 137 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Эдгээр хөрөнгүүд 2004-2021 онд ашиглах хугацаа дууссан байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д " Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасны дагуу тодорхой ажил зохион байгуулж, шийдвэрлэх.

2.1 Илрүүлэлт: Тайлант нийт 4.8 сая төгрөгийн шатахууныг төсвийн хөрөнгөөр худалдан авч бүртгэсэн. Зарцуулалтыг шалгахад Жолоочийн зарим замын хуудсанд машины талаарх мэдээлэл байхгүй буюу машины дугаар, марк бичигдээгүй албан хэрэгцээний машин мөн эсэх нь тодорхойгүй, хаашаа явсан чиглэл бичигдээгүй, нягтлан бодогч тооцоо бодоогүй, гарын үсэг зурсан. Автомашин ашигласан албан тушаалтан өөр өөр байхад жолооч гарын үсэг зурсан. Жолоочийн замын хуудсыг тухай бүр хөтлөөгүй, сард 1 удаа бөөн дүнгээр 1 замын хуудас бөглөсөн зэрэг зөрчилтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны баримт бүртгэлийн

маягтыг нөхөх заавар"-ын 6.4-т "Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэж заасныг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны баримт бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.4-т "Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	9	58.7	3	42.1	1	0.4	3	16.2	2	
	НИЙТ	9	58.7	3	42.1	1	0.4	3	16.2	2	